Эм зүйчийн цогц чадамжийн судалгааны зарим үр дүн

Б.Хандсүрэн[1], Б.Даваадулам[1], Д.Шинэзаяа[1], Д.Даваадагва[1], С.Пүрэвсүрэн[1]

[1]АШУҮИС, Эм зүйн сургууль, Эмнэлзүйн эм зүй, зохион байгуулалтын тэнхим
Цахим шуудан: dpt21e003@gt.mnums.edu.mn, Утас: 88039006

Түлхүүр үг:

Зохион байгуулалт
Менежментийн чадамж
Мэргэжлийн/хувь хүний чадамж
Сургалтын хөтөлбөр
Эм зүйн тусламж үйлчилгээ

Товч утга:

Үндэслэл: Олон улсын Эм зүйн холбоо (ОУЭЗХ)-ны эм зүйчийн цогц чадамжийн хүрээ нь эм зүйн нийгмийн эрүүл мэндийн, эм зүйн тусламжийн, зохион байгуулалт, менежментийн болон мэргэжлийн/хувь хүний чадамж гэсэн үндсэн дөрвөн бүрдэлтэй. **Зорилго:** АШУҮИС-ийн Эм зүйн сургууль Монгол улсдаа анх удаа "Эм зүйч мэргэжилтний цогц чадамж"-ийг 2015 онд боловсруулан хэрэгжүүлж байна. Эм зүйчийн зохион байгуулалт, менежментийн болон мэргэжлийн/хувь хүний чадамжийг тодорхойлох зорилготой. **Арга, аргачлал:** Уг судалгааг дескриптив загвараар, нэг агшны аргаар хийж гүйцэтгэв. ОУЭЗХ-ын эм зүйчийн цогц чадамжийн хүрээний зохион байгуулалт, менежментийн ба мэргэжлийн/хувь хүний чадамжийн асуумжийг судалгаанд ашиглав. **Үр дүн:** Судалгаанд нийт 340 эм зүйч оролцсон ба судалгаанд оролцогчдын 92.1% нь эмэгтэй, 7.9% нь эрэгтэй, дундаж нас 32.57±8.11 жил, ажилласан дундаж жил 7.065±6.734, эдгээрийн 70.3% нь Улаанбаатарт, 44.11% нь нийтийн үйлчилгээтэй эмийн санд ажилладаг байв. Судалгаанд оролцогчдын 63.12% нь мэргэшил олгох сургалтад хамрагдсан ба 37.26% нь эм зүйн албаны менежерийн, 34.6% нь эмнэлзүйн эм зүйчийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан байна. Зохион байгуулалт, менежментийн чадамжаас хамгийн өндөр оноог эмийн хангамжийн менежмент (3.732±0.693), хамгийн бага оноог төсөв ба нөхөн олговрын чадамж (3.154±0.837) авсан ба нийт дундаж оноо 3.556±0.621 байв. Мэргэжлийн/хувь хүний цогц чадамжаас хамгийн өндөр оноог харилцааны ур чадварын (3.849±0.614), хамгийн бага оноог ажлын байран дахь чанарын баталгаажилт ба судалгааны чадамж (3.511±0.675) авсан ба дундаж оноо 3.657±0.556 байгаа нь тус тус тодорхойлогдлоо. **Дүгнэлт:** 1. Судалгаанд хамрагдсан эм зүйчдийн зохион байгуулалт, менежментийн цогц чадамжийн дундаж оноо 3.556±0.621, 84.42% нь 3.0-аас дээш оноотой буюу дундаас дээш чадамжтай байна. 2. Судалгаанд хамрагдсан эм зүйчдийн мэргэжлийн, хувь хүний цогц чадамжийн дундаж оноо 3.657±0.556, 91.26% нь 3.0-аас дээш оноотой буюу дундаас дээш чадамжтай байна.

Үндэслэл: Олон улсад эм зүйн тусламж "Бүтээгдэхүүнд чиглэсэн тусламж"-аас "Эмчлүүлэгч төвтэй тусламж"-д шилжсэнтэй холбоотойгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллага эм зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөрт суурь шинжлэх ухаан, эм зүй, био-анагаах, эмнэлзүй, нийгэм эдийн засгийн болон зан үйлийн шинжлэх ухааныг тохиромжтой харьцаагаар тусгаж практик үйл ажиллагааны туршлага суулгахад анхаарахыг зөвлөмж болгосон байдаг.[1] Дэлхий дахинд эм зүйн сургуулиуд эм зүйчийн хувьсан өөрчлөгдөж буй ажил үүрэгт нийцүүлэн эм зүйн боловсролыг загварчилж, эмчлүүлэгч төвтэй эм зүйн тусламж үзүүлэх чадамжийг олгох хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.[2] Олон улсын эм зүйн холбооноос (ОУЭЗХ) 2013 онд гаргасан "Дэлхийн эм зүйн боловсролын тайлан"-гаас харахад хөгжилтэй орнууд эмийн оновчтой эмчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж, эмийн эмчилгээний үр дагаварт хариуцлага хүлээх, эмчлүүлэгчид үзүүлэх тусламжийг багаар үзүүлэх чадвартай эм зүйч бэлтгэх чадамжид суурилсан хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бол

хөгжингүй орнууд зайлшгүй шаардлагатай эмийн бүх нийтийн хүртээмжийг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа ба сүүлийн жилүүдэд эмчлүүлэгч төвтэй тусламж, нийгмийн эрүүл мэндийн тусламжид чиглэсэн хөтөлбөрт шилжиж байна.[3]

ОУЭЗХ эм зүйчийн цогц чадамжийн хүрээг 2012 онд анх удаа боловсруулсан[4] ба тус баримт бичгийг 2020 дахин шинэчлэн боловсруулсан.[5] Тус баримт бичигт эм зүйчийн эзэмших цогц чадамжийг эм зүйн нийгмийн эрүүл мэндийн, эм зүйн тусламжийн, зохион байгуулалт, менежментийн болон мэргэжлийн/хувь хүний чадамж гэсэн үндсэн дөрвөн бүрдэлд хуваан авч үзсэн. Монгол улсдаа Эм зүйн тусламж, эм зүйн боловсролын олон улсын чиг хандлагад нийцүүлэн эм зүйч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажлыг анх удаа АШУҮИС-ийн Эм зүйн сургууль 2004 оноос эхлүүлж эмчлүүлэгч төвтэй тусламжид чиглэсэн хөтөлбөрийг 2008 онд батлуулан, 2015 онд "Эм зүйч мэргэжилтний цогц чадамж"-ийг 4 цогц чадамжийн хүрээнд, 13 бүрдэлтэйгээр боловсруулан хэрэгжүүлж байна.[6-7] АШУҮИС-ийн Эм зүйн сургууль нь эм зүйчийн цогц чадамжийн хүрээг 2015 онд боловсруулан хэрэгжүүлж байна. Уг баримт бичгийг ОУЭЗХ-оос 2020 онд боловсруулан гаргасан эм зүйчийн цогц чадамжийн хүрээтэй нийцүүлэн, өөрчлөн, шинэчлэн боловсруулах шаардлагатай байна. Манай улсад эм зүйчийн чадамжийн талаар судалгаа хомс байгаа нь энэхүү судалгааны үндэслэл боллоо.

Зорилго: Эм зүйчийн зүйчийн цогц чадамжийг судлах.

Зорилт:

1. Эм зүйчийн зохион байгуулалт, менежментийн чадамжийг тодорхойлох
2. Эм зүйчийн мэргэжлийн/хувь хүний чадамжийг тодорхойлох

Арга, аргачлал: Судалгааг дескриптив загвараар, нэг агшингийн аргаар хийж гүйцэтгэлээ. Бид судалгаандаа Монгол улсын эм зүйн салбарт ажиллаж буй эм зүйчдийг санамсаргүй түүврийн аргаар судалгаанд хамруулав. Судалгааны түүврийг нэг агшны загвараар эх олонлогийн хэмжээ мэдэгдэж байгаа нөхцөлд тархалт тодорхойлох судалгаанд ашигладаг томьёогоор бодолт хийн эх олонлогийн хэмжээг Монгол улсад 2021 онд ажиллаж байсан эм зүйчид (N=2949)-ийн тоог суурь үзүүлэлт болгон авч 95 хувийн магадлал, алдааны хязгаар 5 хувиар тооцон нийт 340 эм зүйчийг судалгаанд хамруулсан. Судалгааг хийж гүйцэтгэхдээ асуумжийг Google form флатформ хэлбэрээр болон цаасан хэлбэрээр авсан.

Асуумж судалгаанд оролцогчийн талаарх ерөнхий мэдээлэл ба цогц чадамж гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдсэн. Судалгаанд оролцогчийн ерөнхий мэдээлэл 8, цогц чадамжийн хэсэг 71 асуулттай. Цогц чадамжийн хэсэг нь Олон улсын Эм зүйн холбооны Эм зүйчийн цогц чадамжийн хүрээний зохион байгуулалт, менежментийн чадамжийн 32, мэргэжлийн, хувь хүний цогц чадамжийн 39 асуулттай байсан бөгөөд ОУЭЗХ-ны цогц чадамжийн асуумжийг Англи хэлнээс Монгол хэл рүү 2 судлаач орчуулж, орчуулгыг нэгтгэсэн. Орчуулсан чадамжийн хүрээг Монгол хэлнээс Англи хэл рүү буцаан орчуулж шалгасан. Судалгаа эхлэхээс өмнө 20 эм зүйчээр асуумжийг бөглүүлж ойлгомжтой байдлыг шалган, хэл зүй найруулгын бага хэмжээний засвар хийж судалгаанд ашигласан.

Үр дүнгийн статистик боловсруулалт: Чадамжийн асуулт бүрийн хариултыг ликертийн 5 хэмжүүрээр өгч, хангалттай сайн-5, хангалттай-4, дунд зэрэг-3, хангалтгүй-2, маш хангалтгүй-1 гэж үнэлсэн. Чадамжийн бүрдэл ба элемент бүрээр дундаж, стандарт хазайлт, хамгийн их ба бага утгыг тооцов. Судалгааны мэдээллийг нэгтгэхдээ Microsoft Excel программ, үр дүнг тооцохдоо SPSS-26.0 программыг ашиглав. Судалгааны өгөгдөлд SPSS–26.0 статистикийн программыг ашиглан тойм статистик боловсруулалт хийж тоон хувьсагчдад дундаж, стандарт хазайлтыг, чанарын хувьсагчдад давтамж, эзлэх хувийг тооцов.

Судалгааны ажлын ёс зүй: АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар судалгааны ажлыг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл авсан. (Хурлын тэмдэглэл 2021.05.21, №3/06/2021). Судалгаанд оролцогчид таниулсан зөвшөөрлийн хуудсыг танилцуулж, судалгаанд оролцохыг зөвшөөрсөн оролцогчдоор асуумжийг бөглүүлсэн.

Үр дүн: Судалгаанд нийт 340 эм зүйч оролцсон ба судалгаанд оролцогчдын 92.1% нь эмэгтэй, 7.9% нь эрэгтэй, дундаж нас 32.57±8.11 жил, насны бүлгээр авч үзвэл 17.87% нь 22-25, 33.08% нь 26-30, 21.67% нь 31-35, 14.07% нь 36-40, 5.7% нь 41-45, 7.6% нь 46-аас дээш настай байв. Судалгаанд оролцогчдын ажилласан дундаж жил 7.065±6.734, тав хүртэлх жил ажилласан 59.32%, 6-10 жил ажилласан 18.25%, 11-15 жил ажилласан 14.45%, 16-20 жил ажилласан 4.18%, 25-с дээш жил ажилласан 4.56% байна. 70.3% нь Улаанбаатарт, 29.7% нь орон нутагт ажилладаг байв.

Эм зүйн салбарт ажиллаж буй чиглэлээр авч үзвэл 44.11% нь нийтийн үйлчилгээтэй эмийн санд, 17.87% нь эмнэлэгт, 11.03% нь эмийн үйлдвэрт, 14.07% нь эм ханган нийлүүлэх байгууллагад, 1.14% нь сургалтын байгууллагад, 2.28% нь эмийн чанарын хяналтын албанд, 7.22% нь төрийн захиргааны байгууллагад, 2.28% нь бусад салбарт ажилладаг байв. Судалгаанд оролцогчдын 63.12% нь мэргэшил олгох сургалтад хамрагдсан, 36.88% нь хамрагдаагүй ба 37.26% нь эм зүйн албаны менежерийн, 34.6% нь эмнэлзүйн эм зүйчийн мэргэжил олгох сургалтад хамрагдсан байна.


Зохион байгуулалт, менежментийн цогц чадамжийг тодорхойлсон дүн: Зохион байгуулалт, менежментийн цогц чадамжийг төсөв ба нөхөн олговор, хүний нөөцийн менежмент, үйлчилгээг сайжруулах, худалдан авах ажиллагаа, эмийн хангамжийн менежмент, ажлын байрны зохион байгуулалт гэсэн чадамжийн нийт 6 элементээр, 32 асуултын дагуу үнэлж, үр дүнг чадамжийн элементийн дундажаар харьцуулав. (Зураг 1) Зохион байгуулалт, менежментийн чадамжийн дундаж оноо 3.556±0.621 байв.



Зураг 1. Зохион байгуулалт, менежментийн чадамжийн дундаж оноог харьцуулсан дүн

Зохион байгуулалт, менежментийн чадамжаас хамгийн өндөр оноог эмийн хангамжийн менежмент (3.732±0.693), хамгийн бага оноог төсөв ба нөхөн олговрын чадамж (3.154±0.837) авсан байв.

Мэргэжлийн/хувь хүний цогц чадамжийг тодорхойлсон дүн: Эм зүйчдийн мэргэжлийн/хувь хүний цогц чадамжийг харилцааны ур чадвар, мэргэшлийн тасралтгүй хөгжлийн, хууль эрх зүй, зохион байгуулалтын үйл ажиллагааны, мэргэжлийн болон ёс зүйн дадал, ажлын байран дахь чанарын баталгаажилт ба судалгаа, хувийн зохион байгуулалт гэсэн чадамжийн нийт 6 элементээр, 39 асуултын дагуу үнэлж, үр дүнг чадамжийн элементийн дундажаар харьцуулав. Мэргэжлийн/хувь хүний цогц чадамжийн дундаж оноо 3.657±0.556 байв. (Зураг 2)



Зураг 2. Мэргэжлийн/хувь хүний чадамжийн дундаж оноог харьцуулсан нь

Мэргэжлийн/хувь хүний цогц чадамжийг чадамжаас хамгийн өндөр оноог харилцааны ур чадварын (3.849±0.614), хамгийн бага оноог ажлын байран дахь чанарын баталгаажилт ба судалгааны чадамж (3.511±0.675) авсан байв.

Эм зүйчийн зохион байгуулалт, менежментийн болон мэргэжлийн/хувь хүний чадамжийн дундаж оноог харьцуулахад 3.627±0.56 байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Эм зүйчийн зохион байгуулалт, менежментийн болон мэргэжлийн/хувь хүний чадамжийг харьцуулсан нь

Чадамж	Оноо			Хамгийн бага утга	Хамгийн их утга	Дундаж утга±Стандарт хазайлт
	1.0-2.9	3.0-3.9	4.0-5.0			
	%	%	%			
Зохион байгуулалт, менежментийн чадамж	15.59	63.5	20.92	1.69	5.0	3.556±0.621
Мэргэжлийн/хувь хүний чадамж	8.75	61.22	30.04	1.82	5.0	3.657±0.556
Нийт дундаж	12.17	66.16	21.67	1.78	5.0	3.627±0.56

Эм зүйчийн зохион байгуулалт, менежментийн болон мэргэжлийн/хувь хүний чадамж ба судалгаанд оролцогчийн нас, ажилласан жил, ажиллаж буй байгууллага, ажиллаж буй газарт статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй. Мэргэшил олгох сургалтад хамрагдсан эсэх болон зохион байгуулалт, менемжентийн чадамж (p=0.017), үүнээс хүний нөөцийн менежмент (p=0.014), эмийн хангамжийн менежмент (p=0.004), ажлын байрны зохион байгуулалтын чадамж (p=0.039), мэргэжлийн/хувь хүний цогц чадамжаас харилцааны ур чадвар (p=0.026)-т статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан.

Мэргэшил олгох сургалтын төрлөөс хамааран зохион байгуулалт, менемжентийн чадамж (p=0.000), мэргэжлийн/хувь хүний чадамж (p=0.006)-д статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. Сургалтын төрлөөс хамааран зохион байгуулалт, менемжентийн чадамжийн бүх элементэд (p<0.005), мэргэжлийн/хувь хүний чадамжийн элементээс хувь зохион байгуулалтаас бусад бүх элемент (p<0.02)-д статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдлаа.

Хэлцэмж: 2023 оны байдлаар Монгол улсад эм зүйч мэргэжилтнийг 8 их дээд сургууль бэлтгэж байгаа ба 2022 оны байдлаар нэг жилд 450 орчим эм зүйч төгсөж, 700 гаруй оюутан эм зүйч болохоор их дээд сургуульд элсэн орж байна.[8] Төгссөн сургуулийн хөтөлбөр, хичээлийн агуулга, сургалтын чанараас хамааран харилцан адилгүй чадамжтай мэргэжилтэн төгсөх магадлалтай тул улс орнууд өөрийн улсын мэргэжилтний цогц чадамжийн хүрээг боловсруулан мөрддөг.[5] АШУҮИС, Эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн холбоо хамтран Эм зүйч мэргэжилтний үндэсний хүрээг боловсруулах ажлыг 2018 оноос эхэлж, олон удаагийн хэлэлцүүлгийг хийгээд байна.

ОУЭЗХ-ны чадамжийн хүрээний дагуу эм зүйчийн цогц чадамжийг тодорхойлох зорилгоор Серби улсад хийсэн судалгааны дүнгээс харахад зохион байгуулалт, менежментийн чадамжаас хамгийн өндөр нь ажлын байрны зохион байгуулалтын чадамжийн оноо 3.47±0.6, хамгийн бага нь үйлчилгээг сайжруулах чадамжийн оноо 2.56±0.671 байгаа нь манай судалгааны үр дүнгээс ялгаатай байна.[9] Энэхүү судалгааны үр дүнгээс харахад хамгийн өндөр

оноог эмийн хангамжийн менежмент 3.732±0.693, хамгийн бага оноог төсөв ба нөхөн олговрын чадамж 3.154±0.837 авсан байв. Мэргэжлийн, хувь хүний цогц чадамжаас хамгийн өндөр оноог харилцааны ур чадварын 3.849±0.614, хамгийн бага оноог ажлын байран дахь чанарын баталгаажилт ба судалгааны чадамж 3.511±0.675 авсан байв. Судлаач Светлана Стойковын Серби улсад хийсэн судалгааны дүнгээс харахад хамгийн өндөр нь мэргэжлийн болон ёс зүйн дадлын чадамжийн дундаж оноо 3.4±0.55, хамгийн бага нь ажлын байран дахь чанарын баталгаажилт ба судалгааны чадамжийн оноо 2.62±0.5 байгаа нь бидний судалгааны үр дүнгээс ялгаатай байна.

Судлаач Stojkov S (2016) нар Сербийн эм зүйчдийн чадамжийг тодорхойлсон судалгаандаа ОУЭЗХ-ны чадамжийн хүрээг ашиглан эм зүйчдийнхээ чадамжийг хөгжүүлэх, боловсролын чанар, үр ашгийг дээшлүүлэх сайн үндэс суурь болгох нь зүйтэй болохыг онцлон тэмдэглэсэн байна. Бидний судалгааны үр дүнгээс харахад мөн ОУЭЗХ-ны чадамжийн хүрээг ашиглан эм зүйчдийнхээ чадамжийг хөгжүүлэх, цогц чадамжийг дахин шинэчлэн боловсруулах шаардлагатай болох нь харагдаж байна. Учир нь эм зүйчийн цогц чадамжийн баримт бичгийг 2015 онд боловсруулахад ОУЭЗХ-ноос 2012 онд гаргасан эм зүйчийн цогц чадамжийн хүрээг ашигласан бол тус байгууллага 2020 онд уг хүрээг дахин шинэчилсэн байна. Эм зүйчийн цогц чадамжийг судлах энэхүү судалгааг ОУЭЗХ-оос 2020 онд боловсруулсан чадамжийн хүрээг ашиглан авсан ба цаашид эм зүйчийн цогц чадамжийн үндэсний хүрээг тогтоон хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Нитима Сумпрадит нарын Тайландын эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн чадамжийг судалсан судалгааны дүнгээс харахад эрүүл мэндийн удирдлагын чадамжийн дундаж оноо 3.40±0.74, харилцааны чадамж 3.85±0.68 байв. Маргита Джаич нарын Хорватид 2018 онд хийсэн судалгааны үр дүнгээс харахад эм зүйчдийн зохион байгуулалт, менежментийн чадамж 3.64±0.336, мэргэжлийн/хувь хүний чадамж 3.41±0.405 дундаж оноотой байв. Уг судалгааны үр дүнтэй харьцуулахад манай эм зүйчдийн зохион байгуулалт, менежментийн болон мэргэжлийн/хувь хүний чадамжийн дундаж оноо өндөр байна.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан эм зүйчдийн зохион байгуулалт, менежментийн цогц чадамжийн дундаж оноо 3.556±0.621, 84.42% нь 3.0-аас дээш оноотой буюу дундаас дээш чадамжтай байна.
2. Судалгаанд хамрагдсан эм зүйчдийн мэргэжлийн, хувь хүний цогц чадамжийн дундаж оноо 3.657±0.556, 91.26% нь 3.0-аас дээш оноотой буюу дундаас дээш чадамжтай байна.

Ном зүй:

1. *The role of the pharmacist in the health care system. Report of a WHO consultative group, New Delhi, India, 13–16 December 1988. Report of a WHO meeting, Tokyo, Japan, 31 August–3 September 1993. Geneva: World Health Organization, 1994 Contract No.: WHO/PHARM/94.569.*
2. *Ines Nunes-da-Cunha, Fernando Fernandez-Llimos. Educational contents for a patient-centred undergraduate pharmacy curriculum. Lisbon: CIPF; 2017. pp:1-5*
3. *International Pharmaceutical Federation. FIPEd Global Education Report. The Hague: FIP; 2013. p:30-31*
4. *FIP. Global competency framework. 2012. 1st version p:6-8*
5. *FIP. Global competency framework. 2020. 2nd version p:3-7*
6. *С.Пүрэвсүрэн. Эмнэлзүйн эм зүйч бэлтгэх орчин үеийн чиг хандлага, эмнэлгийн тусламж үйлчилгээнд эмнэлзүйн эм зүйчийн гүйцэтгэх үүрэг. Эм зүй сэтгүүл. 2019 №1 (62). х. 98-101*
7. *Мэргэжилтний цогц чадамж. АШУҮИС. Улаанбаатар. 2016 х 362-398*
8. *Ministry of education and science. Дээд боловсролын салбарын 2020-2021 оны хичээлийн жилийн статистик. HTTPS://WWW.MEDS.GOV.MN/POSTS?CATEGORY_ID=11403 2021.01.20 X4-12*
9. *Stojkov S, et al. Assessment and self-assessment of the pharmacists' competencies using the Global Competency Framework (GbCF) in Serbia. Vojnosanit Pregl 2016; 73(9) p:803–810.*
10. *Nithima Sumpradit et.al. Comparison of self-reported professional competency across pharmacy education programs: a survey of Thai pharmacy graduates enrolled in the public service program. Advances in Medical Education and Practice 2014:5. 347-357.*
11. *Držaić et al. Identifying self-assessed competencies and areas for improvement within community pharmacist-preceptors support during pre-registration training. BMC Medical Education. (2018) 18:303. https://doi.org/10.1186/s12909-018-1413-x*

Some results of the pharmacist competency survey

Khandsuren B[1], Davaadulam B[1], Shinezaya D[1], Davaadagva D[1], Purevsuren S[1]

[1]Department of Clinical Pharmacy and Management, School of Pharmacy, MNUMS
E-mail: dpt21e003@gt.mnums.edu.mn, Tel: +976-88039006

Background: The International Pharmaceutical Federation's Global Competency Framework for pharmacists has four main components: pharmaceutical public health, pharmaceutical care, organization and management, and professional/personal competencies.
Aim: The School of Pharmacy of the Mongolian National University of Medical Sciences developed and implemented the "Competencies of a Pharmacist" for the first time in Mongolia in 2015.
Materials and Methods: The cross-sectional study was conducted using a descriptive design to determine pharmacists' organization and management, and professional/personal competencies. The organization and management and professional/personal competence questionnaire of the International Pharmaceutical Federation's Global Competency Framework were used for this study.
Results: Three hundred forty pharmacists participated in the study; 92.1% were women, the average age was 32.57±8.11, the average years of work was 7.065±6.734, 70.3% worked in Ulaanbaatar, and 44.11% worked in community pharmacies. 63.12% of the study participants completed qualification training, 37.26% of the respondents completed the pharmacy manager training, and 34.6% of clinical pharmacists. Among organization and management competencies, the highest score was obtained for drug supply management (3.732±0.693), the lowest for budget and reimbursement competencies (3.154±0.837), and the total mean score was 3.556±0.621. Among professional/personal competencies, the highest score was obtained for communication skills (3.849±0.614), the lowest for quality assurance and research competencies in the workplace (3.511±0.675), and the mean score was 3.657±0.556.
Conclusion:

1. The average score of the organization and comprehensive management competence of the pharmacists involved in the study is 3.556±0.621, and 84.42% of them have a score above 3.0 or above average skill.
2. The average score of the professional and personal comprehensive competence of the pharmacists involved in the study is 3.657±0.556 and 91.26% of them have a score above 3.0 or above average competence.

Keywords: Organization and managerial competencies, Professional/personal competencies, Training programs, and Pharmaceutical care